



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“БАГАНУУР ТООСГО” ТӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/103/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Ц.Хосжаргал  
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn  
Ахлах аудитор: Б.Энхжин  
Утас: 260512 Цахим хаяг: enkhjinb@audit.gov.mn  
Гэрээгээр гүйцэтгэсэн “Акпар-Аудит” ХХК-ийн  
Захирал Х.Баянбай  
Утас: 11462131 Цахим хаяг: akpar.audit@gmail.com

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	7
3.4 Материаллаг байдал .....	7
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	8
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	8
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	8
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	9
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	10
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	10
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	10
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
7. Аудитын илрүүлэлт .....	11
7.1 Залруулсан алдаа .....	11
7.2 Зөвлөмж.....	11
8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	13

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УЗ	Удирдах зөвлөл
ШШГЕГ	Шүүхийн шийдвэрийн ерөнхий газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БАГАНУУР ТООСГО ТӨААТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ, АХМАД Э.ДАШРАВЖИР  
ТАНАА

2022.03.15 № 07/594  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хараат бус аудиторын тайлан

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 12 сарын 30-ны А/211 дугаар тушаалаар 2021 оны нийт орлогыг 315.3 сая төгрөгөөр, дээд шатны байгууллагад төвлөрүүлэх дотоод орлогыг 30.0 сая төгрөг байхаар баталж, зардал болон ашгийг батлаагүй байна.

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 30 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 70.0 хувьтай гэж тайлагнасан байна.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	23,167,325.47	17,833,589.27
1.1.2	Дансны авлага	-	-
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	46,725,550.00	30,083,500.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	29,430,741.66	62,377,185.18
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>99,323,617.13</b>	<b>110,294,274.45</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	178,776,341.74	163,907,982.58
1.2.2	Биет бус хөрөнгө	457,692.38	457,692.38
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>179,234,034.12</b>	<b>164,365,674.96</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>278,557,651.25</b>	<b>274,659,949.41</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	4,053,052.70	-
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.7	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>4,053,052.70</b>	-
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	-	-
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>4,053,052.70</b>	-
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	192,291,669.83	192,291,669.83
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	117,668,893.04	117,668,893.04
2.3.6	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.7	Хуримтлагдсан ашиг	(35,455,964.32)	(35,300,613.46)
<b>2.3.8</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>274,504,598.55</b>	<b>274,659,949.41</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>278,557,651.25</b>	<b>274,659,949.41</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	261,673,467.71	222,633,855.26
2	Борлуулалтын өртөг	116,797,566.71	103,314,191.15
<b>3</b>	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>144,875,901.00</b>	<b>119,319,664.11</b>
4	Түрээсийн орлого	518,181.83	681,818.20
5	Хүүнийн орлого	3,851.21	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	11,263,400.00	30,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	74,373,399.21	89,614,447.25
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	8,274,553.40	
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	(20,000,000.00)	(30,000,000.00)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>54,013,381.43</b>	<b>417,035.06</b>
19	Орлогын татварын зардал	4,053,052.70	261,684.20
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>49,960,328.73</b>	<b>155,350.86</b>
<b>21</b>	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>49,960,328.73</b>	<b>155,350.86</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>		
<b>25</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	/төгрөгөөр/		
		Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>192,291,669.83</b>	<b>117,668,893.04</b>	<b>-85,416,293.05</b>	<b>224,544,269.82</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	49,960,328.73	49,960,328.73
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-

<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>192,291,669.83</b>	<b>117,668,893.04</b>	<b>-35,455,964.32</b>	<b>274,504,598.55</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	155,350.86	155,350.86
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>192,291,669.83</b>	<b>117,668,893.04</b>	<b>(35,300,613.46)</b>	<b>274,659,949.41</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>254,750,145.00</b>	<b>265,205,248.00</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	249,110,145.00	259,255,149.00
Бусад мөнгөн орлого	5,640,000.00	5,950,099.00
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>215,502,920.75</b>	<b>240,538,984.20</b>
Ажиллагчдад төлсөн	99,459,289.45	90,728,870.69
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,239,989.49	1,261,449.35
Бараа материал худалдан авахад төлсөн	33,665,400.00	38,988,832.00
Ашиглалтын зардалд төлсөн	4,487,072.25	18,571,193.00
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	34,652,500.00	46,683,550.00
Хүүнийн төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	19,620,701.56	11,447,259.16
Даатгалын төлбөрт төлсөн	257,850.00	597,850.00
Бусад мөнгөн зарлага	22,120,118.00	32,259,980.00
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>39,247,224.25</b>	<b>24,666,263.80</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,851.21</b>	<b>0.00</b>
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	3,851.21	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,851.21</b>	<b>-</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>-</b>	<b>-</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Бусад	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>20,000,000.00</b>	<b>30,000,000.00</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	20,000,000.00	30,000,000.00
Бусад	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(20,000,000.00)</b>	<b>(30,000,000.00)</b>
Валютын ханшийн зөрүү	-	-
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>19,251,075.46</b>	<b>(5,333,736.20)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,916,250.01</b>	<b>23,167,325.47</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>23,167,325.47</b>	<b>17,833,589.27</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Багануур тоосго ТӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, улсын бүртгэлийн гэрчилгээ дэх өмчийн дүн, нэмэгдсэн өртгийн албан татвар, найдваргүй авлагатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 10-аас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Акпар-Аудит ХХК-ийн, ахлах аудитор Б.Эрдэнэсүрэн, аудиторын туслах Э.Оюударь нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Х.Баянбай тус тус хэрэгжүүлсэн.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 3/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардал 106.7 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр тогтоосон.



Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, тус газрын жилийн зорилтот түвшин, түүний биелэлтийг орлогын үзүүлэлтээр тооцдог тул тайлант оны борлуулалтын орлогыг суурь үзүүлэлт болгон сонгож, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны борлуулалтын орлогыг сонгосноор материаллаг байдал 4.7 сая төгрөг болж өөрчлөгдөв.

#### **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

##### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Багануур тоосго ТӨААТҮГ -ын зорилгыг “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу хоригдлыг ажлын байраар хангах чиглэлд гол анхаарлаа хандуулан төрөл бүрийн барилгын материал үйлдвэрлэн, газар тариалан эрхэлж, мод үржүүлэг, ойн цэвэрлэгээний аж ахуй, мал аж ахуй эрхлэн байгууллагын хэрэгцээнд болон зах зээлд бүтээгдэхүүн нийлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Үйлдвэрийн газрын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий газраас баталсан төлөвлөгөөний дагуу барилгын материал, төмс хүнсний ногоо, буудай үйлдвэрлэж, салбар нэгжид хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх;
- Байгууллагын албан хаагч, ажиллагсад, бусад захиалагчийн хэрэгцээнд чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг худалдан борлуулах;
- Техник, технологийн дэвшил нэвтрүүлэх, тоног төхөөрөмж туршин нэвтрүүлэх, зохион бүтээх, шинэ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах, туршлага солилцох;
- Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨААТҮГ гэсэн статустай байгаа ба өмчийг 100.0 хувь төр буюу Хууль зүй, дотоод хэргийн яам эзэмшиж байна.

##### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Багануур тоосго ТӨААТҮГ нь ШШГЕГ-ын даргын 2017 оны А/256 дугаар тушаалыг үндэслэн байгуулагдсан байна. Энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 259 дүгээр зүйлийн 259.4 “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага харьяандаа сургалт, судалгаа, шинжилгээ явуулах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих шуурхай удирдлагын нэгж болон үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүү, хангалт, архив, урлаг, спорт хариуцсан нэгжтэй байна” гэсэн заалттай нийцэж байна.

Үйлдвэрийн газрын дүрмийн 7 дугаар бүлгийн 7.1-д “ Үйлдвэрийн газрын эрх барих байгууллага нь Ерөнхий газрын даргын тушаалаар байгуулагдсан удирдах зөвлөл байна”, 7.2 “Удирдах зөвлөлд Ерөнхий газрын санхүү, төсвийн асуудал хариуцсан газрын дарга, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төлөөлөл, үйлдвэрийн газрын захирал тус тус багтана”, 7.6 “Удирдах зөвлөл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ...” гэж заасны дагуу удирдах зөвлөл 7 гишүүнтэй байгуулагдсан боловч дүрмийн дагуу ажиллахгүй байгаа нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 259 дүгээр зүйлийн 259.4, 262 дугаар зүйлийн 262.1.9 заалттай нийцэхгүй, ШШГЕГ-ын даргын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 21 дүгээр хуралдааны шийдвэр хэрэгжихгүй үр дагавартай байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх тухай” 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 06/502 тоот албан бичгийн дагуу хэмнэлтийн горимд шилжин ажилласан байна. Байгууллагын бүтэц,

орон тоог ШШГЕГ-ын 2020 оны 12 сарын 30-ны өдрийн А/211 тоот тушаалаар 6 орон тоо баталснаас 2021 онд 4 орон тоотой ажилласан, давхардсан орон тоо байхгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Багануур тоосго ТӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	23,167.3	17,833.6	(5,333.7)
Бусад авлага	46,725.6	30,083.5	(16,642.1)
Бараа материал	29,430.7	62,377.2	32,946.4
Үндсэн хөрөнгө	178,776.3	163,908.0	(14,868.3)
Биет бус хөрөнгө	457.7	457.7	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>278,557.6</b>	<b>274,660.0</b>	<b>(3,897.6)</b>
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>4,053.1</b>	<b>-</b>	<b>(4,053.1)</b>
Богино хугацаат өглөг	4,053.1	-	(4,053.1)
Урт хугацаат өглөг	-	-	-
Эздийн өмч	192,291.7	192,291.7	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>196,344.8</b>	<b>192,291.7</b>	<b>(4,053.1)</b>

Банк дахь харилцах дансанд 17.8 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд бусад авлага 30.1 сая төгрөг байна. Тайлант онд харилцагчдаас авах авлага 16.6 сая төгрөгөөр барагдсан нь авлагын бууралтад нөлөөлжээ. Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 15.7 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 14.4 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлага нь Багануур дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 103/ШШ2021/00340 шийдвэрээр хариуцагчийн хаяг тодорхой болсон тохиолдолд дахин нэхэмжлэх гаргах эрхтэйгээр буцаагдаж, эцэслэн шийдвэрлэгдээгүй авлага байна.

Тайлант онд орлогын төлөвлөгөө биелээгүйгээс хөрөнгө оруулалт хийгдээгүй, хөрөнгө нэмэгдээгүй байна. Үндсэн хөрөнгийн дүн тайлант хугацааны элэгдлийн зардал болох 14.9 сая төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн дансанд оны эхэнд бүртгэлтэй байсан татварын өглөгийг төлж барагдуулсан бөгөөд оны эцэст өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт ирээдүйд байгууллагад эдийн засгийн үр ашиг, өгөөж бий болох боломжтой буюу магадлалтай байх, зардлын дүн эсвэл өртгийн найдвартай, үнэн зөв хэмжих боломжтой байх шалгуурыг хангасан нөхцөлд зардлыг хүлээн зөвшөөрөхөөр тусгасан байна. Мөн орлого, зардал зохицох зарчмын дагуу гарсан зардал болон өртгийг түүнтэй холбоотой олсон орлогод шууд хамааруулах үндсэн дээр хүлээн зөвшөөрнө. Энэ зарчмын дагуу ажил гүйлгээ болон бусад үйл явдлын үр дүнд шууд бий болсон орлого, зардлыг нэгэн зэрэг хамтад нь хүлээн зөвшөөрөхийг шаарддаг тул үйлчилгээний өртгийг түүнтэй холбоотой орох орлогод нь шууд хамааруулан орлого, зардлыг уялдуулан хүлээн зөвшөөрнө гэж заажээ. Үйл ажиллагааны зардлыг тайлант хугацааны туршид аккруэл суурьт үндэслэн холбогдох зардлын

данснуудад хуримтлуулан бүртгэх ба аккруэл суурьт бүртгэлийн дагуу ажил гүйлгээ гарсан бөгөөд мөнгөн дүнг нь хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед төлбөр төлөгдсөн эсэхээс үл хамааран гарсан зардлаас тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт түүхий эд материал, хоригдол, ялтны ажлын хөлс, сэлбэг хэрэгсэл, урсгал засвар, түрээсийн зардлуудыг хамруулсан байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Багануур тоосго ТӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ШШГЕГ-ын 2020 оны 12 сарын 30-ны А/211 дугаар тушаалаар Багануур тоосго ТӨААТҮГ-ын 2021 оны үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 315.3 сая төгрөгөөр, дээд байгууллагад төвлөрүүлэх дотоод орлогыг 30.0 сая төгрөг байхаар тогтоосон байна. Гүйцэтгэлээр 237.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 30.0 сая төгрөгийг дээд байгууллагад 100 хувь төвлөрүүлж ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 237.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 77.7 сая төгрөг буюу 24.6 хувиар тасарсан нь ковидын нөхцөл байдлаас түүхий эдийн татан авалт хойшилж, үйлдвэр эхлүүлэх цаг хугацаа оройтсон, борлуулалт буурсан, үйлдвэрийн тоног төхөөрөмж, технологи хоцрогдсоноос чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэж чаддаггүй, гадаа орчинд үйлдвэрлэлээ явуулдаг учраас цаг агаараас хамаарч бороо их орсон тул тоосго, блокны хатаах үйл ажиллагаа удааширсан зэргээс шалтгаалжээ.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Багануур тоосго ТӨААТҮГ нь тайлант онд нийт 788.9 сая төгрөгийн 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 147 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

#### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Тус газрын өөрийн хөрөнгийн хэмжээ санхүүгийн тайланд 192.3 сая төгрөг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд 561.1 сая төгрөгөөр бүртгэгдэж, 368.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ” заалтад нийцээгүй, “Үнэлгээ болон хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гарсан зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөх

2. “Багануур тоосго” ТӨААТҮГ-ын үйлдвэрлэлт, борлуулалт, орлогын төлөвлөгөө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” заалттай нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТӨААТҮГ-ын зорилтот түвшний төлөвлөгөөтэй ижил загвараар батлуулах зөвлөмж өгөх

3. Үйлдвэрийн газрын дүрмийн дагуу удирдах зөвлөл 7 гишүүнтэй байгуулагдсан боловч нэг ч удаа хуралдаагүй байгаа нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 259 дүгээр зүйлийн 259.4, 262 дугаар зүйлийн 262.1.9 заалттай нийцэхгүй, ШШГЕГ-ын даргын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 21 дүгээр хуралдааны шийдвэр хэрэгжихгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Удирдах зөвлөлийг хууль, дүрмийн дагуу ажиллуулах талаар зөвлөмж өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, өөрийн хөрөнгийн хэмжээ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, батлуулсан төлөвлөгөө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, удирдах зөвлөл ажиллахгүй байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## **6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Завсрын аудитаар 1.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад зөрчлийг арилгасан, 3 зөвлөмж өгсөн нь арилаагүй байгаа тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

## **7. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 8 алдаа зөрчил илэрснээс, 1 алдааг залруулж, 7 алдаа зөрчилд 7 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 3.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 5.1 мянган төгрөгийн түвшинээс 1.9 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### **7.1 Залруулсан алдаа**

Санхүүгийн тайланд тусгасан боловч Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд 4.9 сая төгрөгийн орлого тайлагнаагүй алдааг залрууллаа.

### **7.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

##### **1.1 Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 24 нэр төрлийн 112.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг боловсруулж, ТӨБЗГ-т хүргүүлээгүй байна. Энэ нь НББОУС 16-д “Үндсэн хөрөнгийг анхны удаа өртгөөр нь,

дараагийн тайлант үед өртгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг ашиглан бүртгэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **1.2 Өгсөн зөвлөмж**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон үнийн шинэчлэн тогтоох саналыг боловсруулж, ТӨБЗГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх

## **2. Авлагатай холбоотой асуудал**

### **2.1. Илрүүлэлт:**

Авлагын дансанд үлдэгдэлтэй байгаа Хан баян ХХК-аас авах олон жил болсон 14.4 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна. НББОУС 2-д “Авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр нь үнэлж тусгана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Өр төлбөрөө барагдуулахгүй байгаа хуулийн этгээдийн эзэн холбогдогчийн хаягийг тодорхой болгон шүүхийн байгууллагад шилжүүлэх.

## **3. НӨАТ-тэй холбоотой асуудал**

### **3.1. Илрүүлэлт:**

Шатахуун нийлүүлэгч компанийн худалдан авалтын и-баримтын илүү шивэлтийг буцаалт хийлгээгүйгээс и-баримтаарх худалдан авалтын дүн, НӨАТ-ын тайлангаас 3.2 сая төгрөгөөр илүү зөрүүтэй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20.2.7 “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” заалтад нийцээгүй, “Үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### **3.2 Өгсөн зөвлөмж:**

Сар бүрийн НӨАТ-ын тайланг гаргахдаа и-баримтаарх худалдан авалтын дүнг нэгбүрчлэн тулгах, илүү шивэлтийг тухайд бүрд нь буцаалт хийж, тайлагнаж байх

## **4. Зардлын бүртгэлтэй холбоотой асуудал**

### **4.1. Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн нийт элэгдлийн зардлыг тайлант оны удирдлагын зардлаар бүртгэж, шууд зардлаар тайлагнасан байгаа нь “Ангилал” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### **4.2. Өгсөн зөвлөмж:**

Бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотой үйлдвэрийн байр, техник, тоног төхөөрөмжийн элэгдлийг үйлдвэрлэлийн өртөгт тооцож байхаар нягтлан бодох бүртгэлээ зохион байгуулах нь зүйтэй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

8. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/									
							Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Багануур тоосго ТӨААТҮГ	САГ-2022/103/СТА	Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 24 нэр төрлийн 112.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг боловсруулж, ТӨБЗГ-т хүргүүлээгүй байна.	ТӨБЗГ-аас зохих журмын дагуу зөвшөөрөл авч, дахин үнэлгээ хийлгэх. Үнэлгээ хийлгэхийг зөвшөөрсөн нөхцөлд дээрх стандартын дагуу тухайн хөрөнгийн харьяалагдаж байгаа ангиллын хөрөнгийг бүхэлд нь үнэлүүлэх хэрэгтэй.	1	-									1	-
2	Багануур тоосго ТӨААТҮГ	САГ-2022/103/СТА	Авлагын дансанд үлдэгдэлтэй байгаа Хан баян ХХК-аас авах олон жил болсон 14.4 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.	Өр төлбөрөө барагдуулахгүй байгаа хуулийн этгээдийн эзэн холбогдогчийн хаягийг тодорхой болгон шүүхийн байгууллагад шилжүүлэх.	1	-									1	-
3	Багануур тоосго ТӨААТҮГ	САГ-2022/103/СТА	Шатахуун нийлүүлэгч компанийн худалдан авалтын и-баримтын илүү шивэлтийг буцаалт	Сар бүрийн НӨАТ-ын тайланг гаргахдаа И-баримтаарх	1	3,181.8									1	3,181.8

			хийлгээгүйгээс и-баримтаарх худалдан авалтын дүн НӨАТ-ын тайлангаас 3.2 сая төгрөгөөр илүү зөрүүтэй.	худалдан авалтын дүнг нэгбүрчлэн шалгадаг байх. Хэрвээ зөрүү үүсвэл буцаалт цаг тухайд нь хийлгэж байх													
4	Багануур тоосго ТӨААТҮГ	САГ-2022/103/СТА	НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын дүнг нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайланд зөрүүтэй тайлагнасан.		1	4,961.0	1	4,961.0									
5	Багануур тоосго ТӨААТҮГ	САГ-2022/103/СТА	Үндсэн хөрөнгийн нийт элэгдлийн зардлыг тайлант оны удирдлагын зардлаар бүртгэж, шууд зардлаар тайлагнасан байна.	Бүтээгдэхүүн үйлдвэрлэхтэй холбоотой үйлдвэрийн байр, техник, тоног төхөөрөмжийн элэгдлийг үйлдвэрлэлийн өртөгт тооцож байхаар нягтлан бодох бүртгэлээ зохион байгуулах нь зүйтэй.	1	-										1	-
<b>ДҮН</b>					<b>5</b>	<b>8,142.8</b>	<b>1</b>	<b>4,961.0</b>								<b>4</b>	<b>3,181.8</b>
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																	
1	Багануур тоосго ТӨААТҮГ	САГ-2022/103/СТА	Тус газрын өөрийн хөрөнгийн хэмжээ санхүүгийн тайланд 192.3 сая төгрөг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд 561.1 сая төгрөгөөр бүртгэгдэж, 368.8 сая төгрөгөөр зөрүүтэй.	Зөрчлийг арилгах	1	-										1	-
2	Багануур тоосго ТӨААТҮГ	САГ-2022/103/СТА	Үйлдвэрлэлт, борлуулалт, орлогын төлөвлөгөө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т	ТӨААТҮГ-ын зорилтот түвшний төлөвлөгөөтэй ижил загвараар батлуулах	1											1	

			“Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” заалттай нийцэхгүй														
3	Багануур тоосго ТӨААТҮГ	САГ-2022/103/СТА	Үйлдвэрийн газрын дүрмийн дагуу удирдах зөвлөл 7 гишүүнтэй байгуулагдсан боловч нэг ч удаа хуралдаагүй	Удирдах зөвлөлийг хууль, дүрмийн дагуу ажиллуулах	1											1	
<b>ДҮН</b>					<b>1</b>	<b>-</b>										<b>1</b>	
<b>НИЙТ ДҮН</b>					<b>8</b>	<b>8,142.8</b>	<b>1</b>	<b>4,961.0</b>								<b>7</b>	<b>3,181.8</b>



